- 30.3. Хэрэв захиалагч ТШЗ-ны 30.2-т заасан жижиг хэмжээний зөрүүг хүлээн зөвшөөрөх нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөхгүй бол тус тендерийг шаардлага хангасан гэж үзнэ.
- 30.4. Захиалагч IV бүлэгт жижиг хэмжээний зөрүүг залруулах аргачлалыг тусгаж болно.
- 30.5. Захиалагч ТШЗ-ны 30.3-т зааснаар жижиг хэмжээний зөрүүг хүлээн зөвшөөрч, тендерийг шаардлага хангасан гэж үзсэн бол тендерийн үнийг ТШЗ-ны 30.4-т заасан аргачлалын дагуу хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 30.6. Шаардлагад нийцсэн тендер гэж ТШЗ-ны 30 дугаар зүйлд заасны дагуу хянан үзэхэд тендерийн баримт бичгийн бүх нөхцөл, шаардлагыг буюу ТШЗ-ны 3-7, 12-25 дугаар зүйлүүдэд заасан шаардлагыг нэгэн зэрэг хангаж байгаа, түүнд заасан баримт бичиг, тендер илгээх маягт болон бусад маягтуудыг зохих ёсоор ирүүлсэн, маягтуудын агуулгад өөрчлөлт оруулаагүй тендерийг хэлнэ.
- 30.7. ТШЗ-ны 30.6-д зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж, уг тендерээс татгалзана.
- 30.8. Захиалагч нь ТШЗ-ны 30.7-д зааснаар тендерээс татгалзахдаа тендерт оролцогч нь ТШЗ-ны 17.1, 18.4, 18.5-д тендерт оролцогчоос шаардахгүй тухай тусгайлан заасан баримт бичгийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн гэж тендерээс татгалзахгүй.
- 31. Тендерийг үнэлэх**
- 31.1. Захиалагч зөвхөн ТШЗ-ны 30.6-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн тендерийг хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 31.2. Хэрэв ТӨХ-д заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар үнэлнэ.

- 31.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын үнэлгээг IV бүлэгт заасан үнэлгээний аргачлал, зааврын дагуу үнэлж харьцуулна.
- 32. Нэг валютад хөрвүүлэх**
- 32.1. Тендерийн үнэ болон Барааны үнийн задаргаанд заасан үнийг ТШЗ-ны 21 дүгээр зүйлд зааснаас өөр валютаар илэрхийлсэн тохиолдолд тендерийг үнэлэхэд тендер шалгаруулалт зарласан өдрийн Монгол банкны албан ханшийг үндэслэн тендерийн үнийг ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан валютад хөрвүүлнэ.
- 33. Арифметик алдааг залруулах**
- 33.1. Шаардлагад нийцсэн гэж үнэлсэн тендерийн үнийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- 33.1.1. нэр төрлийн мөр дэх нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэгж үнийг үндэслэн түүний мөр дэх нийт үнийг залруулна. Харин нэгж үнийн аравтын орны таслалыг илэрхий алдсан гэж үзвэл тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна;
- 33.1.2. мөр дэх үнийн нийлбэр эсхүл ялгаварт алдаа байвал мөр дэх үнийг үндэслэн нийт үнийг залруулна;
- 33.1.3. тоо болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоон дүнг залруулна. Харин үгээр илэрхийлсэн дүн нь арифметик алдаанаас шалтгаалсан бол ТШЗ-ны 33.1.1, 33.1.2-т нийцүүлэн тоогоор илэрхийлсэн дүнг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 33.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг тендерт оролцогчид хүргүүлнэ.
- 34. Тендерт оролцогчид давуу эрх олгох**
- 34.1. Захиалагч нь хуулийн 10.1.1, 10.1.3, 10.1.6-д заасан этгээдэд давуу эрх олгох бол Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотолж ирүүлсэн барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 34.2. ТШЗ-ны 34.1-т заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй ба энэ нь тухайн тендерт оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 35. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 35.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:
- 35.1.1. ТШЗ-ны 20 дугаар зүйлд зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;



- 35.1.2. ТШЗ-ны 33.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
- 35.1.3. ТШЗ-ны 20.4-т заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
- 35.1.4. ТШЗ-ны 35.1.1-35.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 32 дугаар зүйлд зааснаар нэг валютад хөрвүүлэх;
- 35.1.5. ТШЗ-ны 34 дүгээр зүйлд зааснаар давуу эрх олгох;
- 35.1.6. ТШЗ-ны 31.2-т заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 35.2. Тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсний дараах үнэ төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн бол хуулийн 30.1.3-ыг үндэслэн уг тендерээс татгалзана.
- 35.3. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
- 35.3.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг ТШЗ-ны 35.1-д заасны дагуу сонгох;
- 35.3.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 37.2-т зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
- 35.3.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 35.4. ТШЗ-ны 16.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

- 35.5. ТШЗ-ны 35.4-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 36. Тендерийг харьцуулах, хэлэлцээ хийх**
- 36.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг сонгохдоо хуулийн 28.7.3-т заасны дагуу тендерүүдийг эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно.
- 36.2. Хуульд заасан үндэслэлээр тендерт оролцогчтой хэлэлцээ хийх тохиолдолд хэлэлцээний үр дүнд түүний тендерийн захиалагчийн тавьсан шаардлага, шалгуур үзүүлэлт, барааны тоо хэмжээнд үл хамаарах хэсэгт өөрчлөлт оруулахыг зөвшөөрнө.
- 37. Тендерт оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 37.1. Захиалагч хэд хэдэн багцад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадалж болно.
- 37.2. ТШЗ-ны 37.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 37.3. Хэрэв тендерт оролцогчийг хэд хэдэн багцад гэрээ байгуулахад шаардлага хангахгүй гэж магадалсан бол түүний гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлагыг хангах нэг, эсхүл түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгоно.
- 37.4. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхыг дахин магадалж шаардлага хангахгүй гэж үзвэл уг тендерээс татгалзана. Энэ тохиолдолд удаах хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж, оролцогчийн чадавхыг мөн адил зарчмаар магадална.

## **Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 38. Мэдэгдэл хүргүүлэх**
- 38.1. Захиалагч дараах мэдэгдлийн аль тохирохыг тендерт оролцогч тус бүрд бичгээр хүргүүлж, тухайн өдөрт багтаан цахим системд байршуулна:
- 38.1.1. “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох ;
- 38.1.2. ТШЗ-ны 38.1.1-т зааснаас бусад шаардлага хангасан тендер ирүүлсэн оролцогчид шалгараагүй тухай мэдэгдэх;
- 38.1.3. ТШЗ-ны 30.7, 35.2-т заасан тендерээс татгалзах.

- 38.2. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон бол энэ тухай шийдвэр, мэдэгдэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг холбогдох журмын дагуу ил болгох тухай ТШЗ-ны 38.1.2, 38.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.
- 38.3. Захиалагч бүх тендерээс татгалзсан бол хуулийн 30.4-т заасан дахин нээлттэй, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах, эсхүл гэрээ шууд байгуулах тухай шийдвэрийг ТШЗ-ны 38.1.3-т заасан мэдэгдэлд дурдана.<sup>1</sup>
- 39. Гэрээ байгуулах эрх олгох**
- 39.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг ТШЗ-ны 38.1.1-д заасан мэдэгдлээр олгоно. Хэрэв “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсэн бол уг үнийг гэрээний үнээр тогтоож, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заана.
- 39.2. Дараах тохиолдолд хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн гэж үзэж тендерийн баталгааг улсын орлого болгоно:
- 39.2.1. гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд дурдсан гэрээний үнийг хүлээн зөвшөөрөөгүй;
- 39.2.2. ТШЗ-ны 40 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй (хэрэв гүйцэтгэлийн баталгаа шаардсан бол);
- 39.2.3. ТШЗ-ны 41 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй.
- 39.3. ТШЗ-ны 39.2-т заасан нөхцөл байдал үүсвэл удаах хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж гэрээ байгуулах эрх олгоно.
- 40. Гүйцэтгэлийн баталгаа**
- 40.1. ТӨХ-д заасан бол шалгарсан тендерт оролцогч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн хавсралт маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 40.2. Гүйцэтгэлийн баталгаа нь ТШЗ-ны 23.3-т заасан хэлбэрээр байж болох ба гадаадын этгээдээс гаргуулах бол ТШЗ-ны 23.4-т заасан шаардлагыг хангасан байна.
- 40.3. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 41.1. Захиалагч ТШЗ-ны 8.5-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын

<sup>1</sup> Гэрээ шууд байгуулах аргаар тендер шалгаруулалт зохион байгуулах үед энэ заалт хамаарахгүй.

**41. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, шалгарсан тендерт оролцогчид хүргүүлнэ.

41.2. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 41.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ. Захиалагчийн тогтоох энэ хугацаа нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтсан байна.

41.3. Шалгарсан тендерт оролцогч ТШЗ-ны 41.2-т заасан хугацааны дотор гэрээг зохих ёсоор баталгаажуулж, гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн бол захиалагч гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

41.4. ТШЗ-ны 41.3-т заасан захиалагчийн үүрэг нь төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад эрх бүхий этгээд, эсхүл шүүхээс гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хуульд зааснаар хүчингүй болгосон, эсхүл хэрэгжилтийг түдгэлзүүлсэн тохиолдолд хамаарахгүй.

**Ё. БУСАД**

**42. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол**

42.1. Тендерт оролцогч тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хууль тогтоомжийн дагуу гаргана.

**43. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалт**

43.1. ТШЗ-ны 1.1-д заасан тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа үед энэ тухай ТӨХ болон тендерийн урилгад заана.

43.2. Захиалагч ТШЗ-ны 43.1-д заасны дагуу зохион байгуулах тендер шалгаруулалтад энэ тендерийн баримт бичгээс гадна “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-д заасан нөхцөлийг мөрдөнө.

43.3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах тендер шалгаруулалтаар худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр бүрэн батлагдах хүртэл гэрээ байгуулахгүй.

43.4. Худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, эсхүл цар хүрээ, хүчин чадлыг өөрчилж, төсөвт өртгийг ТШЗ-ны 2.1-т зааснаас өөрөөр баталсан бол урьдчилсан худалдан авах ажиллагааг хэрэгжих боломжгүй болсон гэж үзэж гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгоно.

43.5. ТШЗ-ны 43.4-т зааснаар гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосонтой холбоотой аливаа эрсдэлийг тендерт оролцогч хариуцна.

**44. Тендер  
шалгаруулалтын  
мэдээллийг  
нийтлэх**

- 44.1. Тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу цахим системээр ил болгоно.
- 44.2. Захиалагч нээлтийн тэмдэглэл, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд олон нийтэд ил тод мэдээлнэ.

## II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

### Санамж

Захиалагч худалдан авах барааны онцлог шинж, тендерт оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендерийн өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Тендерийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. ТӨХ нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба ТӨХ-д мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Тендерт оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн тендерт оролцогчийг тухайн бараа нийлүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан баримт бичгүүдээс аль тохирох баримт бичгийг сонгож ТӨХ-д тусгайлан заана;
4. Тендерт оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг тендерт оролцогчоос шаардахгүй;
5. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, тендерийн баталгаа, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

## II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: <b>Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр: <b>Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендерийн урилгын дугаар: <b>БГДЭМТ/202210006</b>
<b>ТШЗ 1.2</b>	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багц №1 Дурангийн иж бүрдэл-80,550,000 төгрөг</b> <b>Багц №2 Мэс заслын тоног төхөөрөмж, хэрэгсэл-473,500,000 төгрөг</b> <b>Багц №3 Лабораторийн тоног төхөөрөмж-122,940,000 төгрөг</b> <b>Багц №4 Шүдний тоног төхөөрөмж-107,500,000 төгрөг</b> <b>Багц №5 Дурангийн тауэр иж бүрдэл-468,786,850 төгрөг</b> <b>Багц №6 Багц 5-дахь Дурангийн тауэрт тохирох үений хагалгааны иж бүрдэл-94,183,150 төгрөг</b> <b>Багц №7 Дурангийн шланк-160,000,000 төгрөг</b> <b>Багц №8 Дурангийн дагалдах тоног төхөөрөмж-92,540,000 төгрөг</b>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсвийн хөрөнгө</b>
<b>ТШЗ 2.1</b>	Нийт төсөвт өртөг: <b>1,600,000,000 төгрөг</b> <b>/Нэг тэрбум зургаан зуун сая/</b>
<b>Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 9.2</b>	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:  Тендерт оролцогч тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр гаргаж болно.  Хүлээн авагчийн нэр: <b>БГДЭМТ-ийн эрүүл мэндийн эдийн засаг, төлөвлөлт хариусан мэргэжилтэн Э.Батзаяа</b>  Хаяг: <b>МУ, УБ хот, БГД, 18-р хороо, Жалханз Хутагт Дамдинбазарын гудамж, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв 8-р давхар, 802 тоот өрөө.</b>

	<p>Утасны дугаар: <b>+976 11 365036, 89096709</b></p> <p>Тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээлэлтэй холбогдуулан захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах эрхтэй ба энэ нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг байна.</p> <p>Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) дэх тендерийн баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлнэ. Ийнхүү нийтэлсэн даруйд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээлэл, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэх үүрэгтэй.</p>
<b>ТШЗ 10.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 13.2</b>	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: <b>“Монгол хэл”</b>
<b>ТШЗ 16.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b> .
<b>ТШЗ 18.2</b>	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p style="padding-left: 40px;">- <b>Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2020, 2021 онуудын дундаж борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 30 хувиас багагүй байна.</b></p>
<b>ТШЗ 18.2.5</b>	<p>Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: <b>“Шаардана”</b>.</p> <p><b>1. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30%-иас багагүй байх. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэг эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➤ <b>Харилцагч банкаас авсан байгууллагын дансны үлдэгдлийн хуулга</b></li> <li>➤ <b>Арилжааны банкаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Судлан үзэж олгох зээлийн тодорхойлолтыг тооцохгүй/</b></li> <li>➤ <b>Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цаасууд</b></li> </ul>



	<b>2. Харилцагч банкаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр, төлбөргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ.</b>
<b>ТШЗ 18.3</b>	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: <b>Санхүүгийн тайланг тендерт оролцогч өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан Сангийн яамны Цахим санхүүгийн тайлан /www.e-balance.mof.gov.mn/-ийн мэдээллийн санд баталгаажсан тендерт оролцогчдын сүүлийн 2 жил буюу 2020, 2021 онуудын борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</b>
<b>ТШЗ 18.6</b>	Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:  <b>Сүүлийн 2 жилийн буюу 2020, 2021 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь 1 удаа нийлүүлсэн байх бөгөөд дараах бичиг баримтыг нотолгоо болгон ирүүлнэ. Үүнд:</b>  <ul style="list-style-type: none"> <li>➢ <b>Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар</b></li> <li>➢ <b>Хүлээлцсэн актын хуулбар</b></li> <li>➢ <b>Захиалагч байгууллагын тоног төхөөрөмж нийлүүлсэн тухай тодорхойлолтыг ирүүлнэ.</b></li> </ul> <p><b>Ижил төстэй ажилд тоног төхөөрөмж нийлүүлсэн туршлагыг тооцно. /Багцад харгалзах тоног төхөөрөмж нийлүүлж байсан туршлагатай бол давуу тал болно./</b></p>
<b>ТШЗ 18.6.1</b>	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардана”.</b>  <b>Хүчин төгөлдөр эмнэлгийн тоног төхөөрөмж худалдах, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг ирүүлнэ.</b>
<b>ТШЗ 18.6.3</b>	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн мэдээлэл: <b>“Шаардана”.</b>  <b>Төслийг хэрэгжүүлэх, гэрээг гүйцэтгэх удирдах албан тушаалтан, зохион байгуулах менежер, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн чиглэлээр мэргэшсэн 2-оос доошгүй хүний нөөц зэрэг хүний нөөцийн багтай байх бөгөөд чадвар, мэргэжил, мэргэшлийг илтгэх боловсролын диплом, үнэмлэх, бусад холбогдох бичиг баримтын хуулбарыг ирүүлнэ.</b>  <b>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүд нь тухайн байгууллагын үндсэн ажилтнаар 6-аас багагүй сарын хугацаанд ажилласан байх шаардлагатай ба тус бүрийн ТҮЦ машинаас авсан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг хавсаргаж ирүүлнэ. Төрийн худалдан авах ажиллагааны Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-р дамжуулан мэдээллийн санд баталгаажсан тендерт оролцогчдын хүний нөөцийн мэдээллийг шалгана.</b>

ТШЗ 18.6.4	<p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: <b>“Шаардлагатай”</b>.</p> <p><i>Сүүлийн 2 жилийн буюу 2020, 2021 онуудад тендерт оролцогчийн туршлагыг харуулах ТӨХ-д заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 5, Маягт 7-ын дагуу бэлтгэсэн мэдээллийг ирүүлнэ.</i></p>
ТШЗ 18.6.7	<p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <b>“Шаардана”</b>.</p> <p><i>Эмнэлгийн тоног төхөөрөмжийг захиалагчийн заасан байршилд суурьлуулахад шаардагдах ажлын өөрийн багаж хэрэгслээр хангагдсан байна.</i></p>
ТШЗ 18.6.8	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: <b>“Шаардана”</b>.</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ <i>Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ</i></li> <li>➢ <i>Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг суурьлуулж ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 24 сарын хугацаанд аливаа эвдрэл гэмтлийг хариуцан ажиллах баталгаат хугацааны мэдэгдлийг ирүүлнэ.</i></li> <li>➢ <i>Тендерийн баримт бичиг, түүнд заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрсөн тухай албан мэдэгдлийг ирүүлнэ.</i></li> <li>➢ <i>Харьяа татвар, нийгмийн даатгал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ. Дээрх лавлагаануудыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> -ээр дамжуулан шалгах ба тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй.</i></li> <li>➢ <i>Гологдол гарсан тухай бүрт яаралтай дутагдлыг арилгах, нийлүүлэх тоног төхөөрөмж нь захиалагчийн шаардлагыг хангаж буй эсэх талаар баталгаа болгон техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх ба тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй танилцуулгыг мөн ирүүлнэ. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтоос зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</i></li> </ul>
ТШЗ 18.7.	<p>Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: <b>“Шаардана”</b>.</p> <p><i>Түншлэлийн гишүүн бүр ТШЗ-ний холбогдох заалтын шаардлагыг хангасан байна.</i></p>
ТШЗ 19.5.	<p>Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх</p>

	хугацаа: <b>Нийлүүлэх барааг ашиглалтад суурьлуулж өгснөөс хойш 24 сарын баталгаат засварын хугацааг албан мэдэгдлээр ирүүлнэ.</b>
<b>ТШЗ 20.5.</b>	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”.</b>
<b>ТШЗ 20.6</b>	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>“Туйм”.</b> <b>Incoterms 2020.</b>
<b>ТШЗ 23.1</b>	Тендерийн баталгааны дүн: Тухайн батлагдсан төсөвт өртгийн 0,5 хувиар тооцож тендерийн баталгааг ирүүлэх ба хүчинтэй байх хугацаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 24.5.3</b>	<p>ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p><b>Тендерт оролцогч нь дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Тендерийн саналыг тендерийн баримт бичигт хавсаргасан маягтын дагуу ирүүлэх ба өөр маягтаар ирүүлсэн нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</b></li> <li><b>2. Барааны үнийн хуваарь болон бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</b></li> <li><b>3. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдлийг ирүүлнэ.</b></li> <li><b>4. Тендерт ирүүлсэн материалуудтай холбоотой асуудлаар гуравдагч этгээдүүдээс тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ.</b></li> <li><b>5. ШШЕГ-аас холбогдох тодорхойлолтыг тендер зарласан өдрөөс хойш авч ирүүлэх.</b></li> <li><b>6. Нийлүүлэх тоног төхөөрөмж нь технологийн хувьд орчин үеийн, дэвшилтэт технологи байх ба ашиглахад энгийн, ажиллагааг хянах боломжтой, олон улсын бүтээгдэхүүний чанарын CE, FDA, ISO, TUV зэрэг стандартуудын аль нэгийг хангасан, ашиглаж байгаагүй шинэ бүтээгдэхүүн байх бөгөөд холбогдох чанарын гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</b></li> <li><b>7. Нийлүүлэх тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн зөвшөөрөл эсвэл албан ёсны төлөөлөгч болохыг нотолсон баримт бичгийг орчуулгын хамт, нийлүүлэх тоног төхөөрөмжийн бодит зураг, үйлдвэрлэгчийн танилцуулга, катологийг тус тус ирүүлнэ.</b></li> <li><b>8. Нийлүүлэх тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэн үзүүлэлтээр хангаж байгааг нотолсон мэдэгдэл, техникийн тодорхойлолттой харьцуулсан хүснэгтийг ирүүлнэ. Харьцуулсан хүснэгтээр ирүүлсэн мэдээлэл үйлдвэрлэгчийн каталоогоос зөрүүтэй байх нөхцөлд үйлдвэрлэгчийн</b></li> </ol>

	<p><i>каталогт заасан техникийн үндсэн үзүүлэлтийг баримтлах үндэслэл болгоно.</i></p> <p><b>9. Нийлүүлэх тоног төхөөрөмжийн баталгаат хугацаан дахь товлотт засвар, үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл, хуваарь, баталгаат хугацаа дууссанаас хойших засвар үйлчилгээ, сэлбэгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үнийн саналыг ирүүлнэ.</b></p>
<b>ТШЗ 25.1.</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:Огноо:</p> <p><b>2022 оны 11 дүгээр сарын 29 өдөр</b></p> <p>Цаг: <b>12 цаг 00 минут</b></p>
<b>ТШЗ 27.1.</b>	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>12 цаг 30 минут</b></p> <p>Тендер нээх газрын хаяг: <b>МУ, УБ хот, БГД, 18-р хороо, Жалханз Хутагт Дамдинбазарын гудамж, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв 8-р давхар, 802 тоот өрөө.</b></p>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
<b>ТШЗ 31.2</b>	<p>Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <b>“Ашиглана”.</b></p> <p><b>Тендерийн баримт бичгийн IV бүлгийн 5-д заасан Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах чанар ба үнэлгээний аргыг ашиглана.</b></p>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>ТШЗ 40.1</b>	<p>Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>“Туйм”.</b></p> <p><b>ТШЗ-ны 8.5-т заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</b></p> <p><b>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4.2 дах заалтын дагуу 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах нөхцөлд захиалагч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгээгчээс шаардана. Гүйцэтгэлийн баталгааны дүн нь хуулийн 43.2 дах заалтын дагуу гэрээний үнийн дүнгийн 3 хувьтай тэнцүү байна.</b></p>
<b>Ё. БУСАД</b>	
<b>ТШЗ 43.1</b>	<p>Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: <b>Үгүй.</b></p>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

*[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.*

*Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.*

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*

#### **Зураг, төсөл**

*Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.*

## **Шалгалт, туршилт**

*[Захиалагч тендерт оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.*

*Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд тендерт оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан тендерт оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.*

*Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]*

## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

Тавигдах ерөнхий шаардлага:

- Эмнэлгийн тоног төхөөрөмж нь технологийн хувьд орчин үеийн, дэвшилтэт технологи байх ба ашиглахад энгийн, ажиллагааг хянах боломжтой, олон улсын бүтээгдэхүүний чанарын CE, FDA, ISO, TUV зэрэг стандартуудын аль нэгийг хангасан ашиглаж байгаагүй шинэ бүтээгдэхүүн байх
- Тухайн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг холбогдох эмч, инженер, мэргэжилтнүүдэд зохион байгуулж тухайн сургалтад хамрагдсан батламж, сертификатыг олгох
- Эмнэлгийн инженер болон ханган нийлүүлэх байгууллагын инженерийн ажил үүргийн жагсаалтыг баталгаажуулан ирүүлэх
- Бүрэн ажиллагааг хангахын тулд бараанд зайлшгүй шаардлагатай бүх нэмэлт ба дагалдах хэрэгслүүдийг хамтад нь санал болгох ба уг нэмэлт болон дагалдах хэрэгслүүд нь ашиглаж байгаагүй шинэ бүтээгдэхүүн байх
- Баталгаат хугацаа 2 жилээс багагүй байх ба баталгаат хугацааны засвар үйлчилгээг ханган нийлүүлэх байгууллага хариуцаж, баталгаат засварын гэрээг захиалагчтай тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээлгэн өгөх үед байгуулах, баталгаат хугацааны засвар үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл, хуваарийг ирүүлэх
- Баталгаат хугацаа дууссаны дараах үйлчилгээ, сэлбэг материалаар хангах боломжтой байх үнийн саналыг тоног төхөөрөмж тус бүр дээр дагалдуулсан байх
- Техникийн үзүүлэлтэд дурдсан дагалдах хэрэгслийг 1 тоног төхөөрөмжид байхаар тооцож бичсэн болно
- Нийлүүлэх аппарат, тоног төхөөрөмжийн ашиглалтын болон засвар үйлчилгээний дараах гарын авлагыг англи, монгол хэл дээр дагалдуулж өгөх, үүнд: хэрэглэгчийн гарын авлага, засвар үйлчилгээний гарын авлага, баталгаат хугацаанд хийх техник үйлчилгээний ажлын график /өдөр тутам, 7 хоног, сарын гэх мэт шалгах хуудас/

Тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслийн техникийн тодорхойлолт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Үзүүлэлт
Багц 1. Дурангийн иж бүрдэл			
1	Ходоодны дуран OPTERA	1	*Olympus үйлдвэрийн системтэй тохирч ажилладаг байх. Ходоод, гэдэсний хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх NBI гэрлийн горимд ажилладаг байх. Харах талбай: 140 Харалтын гүн: 2-100 мм

			Эргэх өнцөг: дээш-210, доош-90, баруун100, зүүн-100 Гадна диаметр: 9.2 мм Уян хэсгийн диаметр: 9.2 мм Ажлын сувгийн диаметр: 2.8 мм Ажлын урт:1030 мм Нийт урт: 1350 мм
2	Бүдүүн гэдэсний дуран OPTERA	1	Баянгол дүүргийн ЭМТ-д ашиглаж буй Olympus үйлдвэрийн системтэй тохирч ажилладаг байх. Ходоод, гэдэсний хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх NBI гэрлийн горимд ажилладаг байх. Харах талбай: 140 Харалтын гүн: 2-100 мм Эргэх өнцөг: дээш-180, доош-180, баруун160, зүүн-160 Гадна диаметр: 12.8 мм Уян хэсгийн диаметр: 12.8 мм Ажлын сувгийн диаметр: 3.7 мм Ажлын урт:1680 мм Нийт урт: 2005 мм
3	Telescope	1	Телескоп 10мм, 30°, HD, хурдан түгжээтэй Үйлдвэрлэсэн улс/бүс: Япон Дурангийн диаметр:10 мм Харах өнцөг:30° Уян хатан байдал:Хатуу Онцлогууд:Түргэн түгжээ, Автоклавт, Багажны тавиур Дурангийн урт:430 мм Дурангийн төрөл:лапароскоп Брэнд:Олимпус байх/Аппаратын тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилготой/ Зориулалтын хэрэглээ: Лапароскопи, ерөнхий мэс засал, хэвлийн хөндийн мэс засалд хэрэглэх боломжтой байх Olympus VISERA ELITE II OTV-S20 процессорт таардаг байх
Багц 2 Мэс заслын тоног төхөөрөмж, хэрэгсэл			
1	Мэс заслын ор	1	Өвчтний жин даац 185кг Нийт уртын хэмжээ 2030мм Өргөн /хажуу тал орсон/ороогүй байдлаар/ 500/556мм Өндөр /тохируулгатай/ 680-1030мм Trendelenburg/ Reverse Trendelenburg 26°/ 26° Lateral Tilt 21° Head plate up/down (manual) +45°/-90° Lower back plate up/down +80°/-40° Leg plate up/down (manual) +20°/-90° Longitudinal shift 300мм Brake system control Механик Удирдлагатай Гэмтлийн хагалгааны иж бүрдэл *С-ARM рентген ашиглах боломжтой байх *Мэдрэлийн мэс заслын хагалгаанд хэрэглэх боломжтой байх



2	Мэс заслын ор	1	<p>Өвчтний жин даац 185кг  Нийт уртын хэмжээ 2030мм  Өргөн /хажуу тал орсон/ороогүй байдлаар/  500/556мм  Өндөр /тохируулгатай/ 680-1030мм  Trendelenburg/ Reverse Trendelenburg 26°/  26°  Lateral Tilt 21°  Head plate up/down (manual) +45°/-90°  Lower back plate up/down +80°/-40°  Leg plate up/down (manual) +20°/-90°  Longitudinal shift 300мм  Brake system control Механик  Удирдлагатай  *С-ARM рентген ашиглах боломжтой байх  *Мэдрэлийн мэс заслын хагалгаанд  хэрэглэх боломжтой байх</p>
3	<p>Өвчтөний хяналтын  монитор  Амин 5 үзүүлэлт үзэх</p>	15	<p>Дэлгэц: TFT 12.1 инч хэмжээтэй, мэдрэгчтэй  Тэжээл: 100-240V AC, 50/60Hz  Хананд тогтоодог суурьтай байх  Батерейтай: +2600mAh, 4-6 цаг ажиллах  боломжтой  Амин 5 үзүүлэлт үзэх:  1. Цусны даралт: Manual, Auto, STAT  горимтой. 1mmHg нарийвчлалтай. Пульс 30-  240 bpm,  · SYS 40-255 mmHg  · DIA 10-195 mmHg  · MEAN 20-215 mmHg  2. цусан дахь хүчилтөрөгч: 0-100%,  нарийвчлал өндөртэй  3. зүрхний бичлэг: мэдрэмж 1.25, 2.5, 5, 10,  20, 40mm/mV, хяналт, оношлогоо, мэс  заслын горимтой  4. Амьсгал: Импеданс арга  5. биеийн халуун хэмжих: 2 сувагтай, 15-  50°C  Сэлбэг олдоцтой байх  Төвийн хяналтын мониторийн системтэй бол  давуу тал болно.  Дагалдах хэрэгсэл бүрэн байх  Бүх талаас харагдах дохионы гэрэлтэй  Ашиглалтын төрлөөс хамаарч дэлгэцийн  харагдах байдлыг өөрчлөх боломжтой байх  Түүхийг 50 өдөр хадгалдаг байх  Мэс заслын өрөөнд ашиглаг боломжтой  Баталгаат хугацаа: 2 жил байх</p>
4	<p>Өвчтөний хяналтын  монитор  Амин 6 үзүүлэлт үзэх</p>	8	<p>Дэлгэц: TFT 12.1 инч хэмжээтэй, мэдрэгчтэй  Тэжээл: 100-240V AC, 50/60Hz  Зөвөөрлөх боломжтой, тэргэнцэрийн өндөр  намыг тохируулдаг, сагстай, 5 дугуйтай  Батерейтай: +2600mAh 4-6 цаг ажиллах  боломжтой  Амин 6 үзүүлэлт үзэх:  1. Цусны даралт: Manual, Auto, STAT  горимтой. 1mmHg нарийвчлалтай. Пульс 30-  240 bpm,</p>

			<ul style="list-style-type: none"> <li>· SYS 40-255 mmHg</li> <li>· DIA 10-195 mmHg</li> <li>· MEAN 20-215 mmHg</li> </ul> <p>2. цусан дахь хүчилтөрөгч: 0-100%, нарийвчлал өндөртэй</p> <p>3. зүрхний бичлэг: мэдрэмж 1.25, 2.5, 5, 10, 20, 40mm/mV, хяналт, оношлогоо, мэс заслын горимтой</p> <p>4. Амьсгал: Импеданс арга</p> <p>5. биеийн халуун хэмжих: 2 сувагтай, 15-50°C</p> <p>6. Цусны шууд даралт хэмжигчтэй Сэлбэг олдоцтой байх Төвийн хяналтын мониторийн системтэй бол давуу тал болно. Дагалдах хэрэгсэл бүрэн байх Бүх талаас харагдах дохионы гэрэлтэй Ашиглалтын төрлөөс хамаарч дэлгэцийн харагдах байдлыг өөрчлөх боломжтой байх Түүхийг 50 өдөр хадгалдаг байх Мэс заслын өрөөнд ашиглаг боломжтой Баталгаат хугацаа: 2 жил байх</p>
5	Өвчтөний хяналтын монитор Амин 7 үзүүлэлт үзэх	2	<p>Дэлгэц: TFT 12.1 инч хэмжээтэй, мэдрэгчтэй Тэжээл: 100-240V AC, 50/60Hz Зөөвөрлөх боломжтой, тэргэнцэрийн өндөр намыг тохируулдаг, сагстай, 5 дугуйтай Батерейтай: +2600mAh 4-6 цаг ажиллах боломжтой Амин 7 үзүүлэлт үзэх:</p> <p>1. Цусны даралт: Manual, Auto, STAT горимтой. 1mmHg нарийвчлалтай. Пульс 30-240 bpm,</p> <ul style="list-style-type: none"> <li>· SYS 40-255 mmHg</li> <li>· DIA 10-195 mmHg</li> <li>· MEAN 20-215 mmHg</li> </ul> <p>2. цусан дахь хүчилтөрөгч: 0-100%, нарийвчлал өндөртэй</p> <p>3. зүрхний бичлэг: мэдрэмж 1.25, 2.5, 5, 10, 20, 40mm/mV, хяналт, оношлогоо, мэс заслын горимтой</p> <p>4. Амьсгалын тоо: Импеданс арга</p> <p>5. биеийн халуун хэмжих: 2 сувагтай, 15-50°C</p> <p>6. Цусны шууд даралт хэмжигчтэй</p> <p>7. Капнография мэдрэгчтэй Сэлбэг олдоцтой байх Төвийн хяналтын мониторийн системтэй бол давуу тал болно. Дагалдах хэрэгсэл бүрэн байх Бүх талаас харагдах дохионы гэрэлтэй Ашиглалтын төрлөөс хамаарч дэлгэцийн харагдах байдлыг өөрчлөх боломжтой байх Түүхийг 50 өдөр хадгалдаг байх Мэс заслын өрөөнд ашиглаг боломжтой Баталгаат хугацаа: 2 жил байх</p>
6	Функциональ ор	10	*Функциональ ор өвчтөнийг зөөвөрлөх зориулалттай бөгөөд 3- аас дээш

			<p>үйлдэлтэй байх</p> <p>* Хэмжээ: 211 см /урт/ х 76см /өргөн/ х 56-89см /өндөр/</p> <p>*Даац:159кг</p> <p>*Цээж өргөгддөг байх</p> <p>*Хөл өргөдөг байх</p> <p>*Дээш доош болох боломжтой байх</p> <p>*Тэжээл: 220В ажилладаг байх</p> <p>*материал: Сайн чанарын ган материалаар хийгдсэн байх</p> <p>*Дугуй бүр түгжигчтэй байх</p> <p>*Дуслын хөлтэй байх</p>
7	Тарианы автомат шахуурга	10	<p>* Төвийн хяналтын мониторийн системд холбогдох боломжтой байх</p> <p>*benefushion esf маркын загвартай дүйцэх</p> <p>*Бүх насны хүнд хэрэглэх боломжтой байх</p> <p>*Түгжих горимтой байх</p> <p>*Бүх тариур ашиглах боломжтой байх</p>
8	Goldmann Applanation tonometry	1	<p>Нүдний даралт хэмжих/биомикроскопид суурилуулах/ *R-900 загварын SL20D загварын биомикроскопид таарах.</p>
9	Сонсголын аппарат	1	<p>сонсголын түвшин тодорхойлох зорилгоор ашиглах зориулалт бүхий аппарат дагалдах хэрэгсэлүүд *Шуугиан өгөх чихэвч-1ш</p> <p>*ясан дамжуулалтыг үнэлэх чихэвч-1ш</p> <p>* Маск үнэлгээ хийх чихэвч -1ш</p> <p>*Тэжээл: 220В</p>
<b>Багц 3 Лабортортийн тоног төхөөрөмж</b>			
1	Бар код хэвлэгч машин	2	<p>Цаасны хэмжээ: 60мм хүртэл байх</p> <p>Хар хэвлэх хурд: 102мм/сек</p> <p>Нарийвчлал: 203 dpi хүртэл</p> <p>Нарийвчлал: 203 dpi (8 цэг/мм)</p> <p>Санах ой: 8 MB SDRAM, 4 MB Flash</p> <p>Хэвлэх өргөн: 2.2" (56мм)</p> <p>Хэвлэх урт: 39" (991мм)</p> <p>Хэвлэх хурд: 4" (102мм)/сек</p> <p>zebra tlp 2824 plus- тай дүйцэхүйц</p>
